



**УЛААНБААТАР  
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2020 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 5/737

Улаанбаатар хот

Г Д.Батсайханыг ажлаас чөлөөлж, Г  
тэтгэмж олгох тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8, 38 дугаар зүйлийн 38.1.1, 40 дугаар зүйлийн 40.1.3, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1, Компанийн Хөдөлмөрийн дотоод журмын 4 дүгээр зүйлийн 4.23, Компанийн Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан 2019-2020 онд мөрдөх Хамтын гэрээний 5 дугаар зүйлийн 5.14 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан Тоолуур, хэмжих хэрэгслийн хэлтсийн инженер /судалгаа, мониторинг/ Даваажавын Батсайхан /122653/-ыг 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс үүрэгт ажлаас нь чөлөөлж, хөдөлмөрийн гэрээг цуцалсугай.

2. Д.Батсайханд эрчим хүчний салбарт 27 жил ажилласны тэтгэмжийг эрчим хүчний салбарт ажилласан жил тутамд салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ /672000/-г 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр тооцож 36,288,000 /гучин зургаан сая хоёр зуун наян найман мянга/ төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийг олгохыг Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /О.Ариунболд/-д зөвшөөрсүгэй.

3. Д.Батсайханы ажлыг хүлээлцүүлж, ээлжийн амралтын олговрыг 25 хоногоор тооцож олгох, холбогдох тооцоог хийж дуусгахыг Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /О.Ариунболд/, Тоолуур, хэмжих хэрэгслийн хэлтсийн дарга /Ж.Баянмөнх/ нарт зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга /Б.Баттүшиг/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Р.ДАГДАН